

Н.ЗОЛЖАРГАЛ: ТАТВАР НЭМНЭ ГЭДЭГ НЬ ШУУД ҮНЭ НЭМЖ БУЙТАЙ АДИЛ

Манай улсын эдийн засгийн ашиг орлогын 25 хувийг бүрдүүлдэг зэс гэгч металлын ханиш дэлхийн зах зээлд хэдэн өдөр дараалан эрс буурлаа. Зөвхөн зэс ч гэлтгүй алт, мөнгө гээд олон түүхий эдийн ханиш өдрөөр бус цаг минутын дотор олон арван доллароор буурч байгаа нь дэлхийн эдийн засгийн шинэ хямрал ирж байгаа дохио мэт харагдаж буй. Тиймээс манай санхүүгийн ертөнцийн удирдлагууд үүнийг хэрхэн харж байгааг сонирхов.

-Зэсийн ханш огцом буурлаа. Юунаас шалтгаалсан бол?

-Сүүлийн хоёр гурван сарын дотор зэсийн ханш 9500-7500 хүртэл буурчихлаа. Ялангуяа, сүүлийн хэд хоногт огцом буулаа. Гэхдээ их хямралын үеийн ханштай харьцуулахад 2-3 дахин их хэвээрээ л байна. Цаашдаа ямар ханштай байх нь гол асуудал юм. Нью-Йоркийн бирж үүнээс хоёр дахин уналттай байгаа Европын зах зээл дэлхийн зах зээл уналтанд ороход нөлөөлсөн. Нийт түүхий эдийн зах зээлийн үнэ найман хувиар буурчихаад байна. Уг нь сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байсан үр тариа, кофеноос эхлээд металл гээд бүх түүхий эдийн ханш сүүлийн хэдэн сарын хугацаанд огцом буурсан. Үүний цаана байгаа гол айдас нь дэлхийн эдийн засаг зогсонги байдалд орох эсвэл өсөлт нь буурах вий гэсэн сэрэмжээс дээрх үйл явдал үүссэн болов уу.

-Тэгэхээр энэ айдас хэр удаан үргэлжлэх байх гэж та бодож байна?

-Дэлхийн хэмжээнд авч үзвэл энэ айдас нь ортой. АНУ, Европын орнууд сүүлийн жилүүдэд нэлээд их хэмжээний бэлэн мөнгө нийлүүллээ. Үүний үр дүнд тэдний эдийн засгийн өсөлт нэлээд саарна. Энэ үзэгдэл ойрын 3-5 жил үргэлжлэх болов уу гэж дэлхийн санхүүгийн зах зээл таамаглаж байсан юм. Энэ хооронд түүхий эдийн үнэ тогтмол өсөөд байсны учир нь бусад эдийн засгийн бүсэд өсөлт нь хурдассан. Үүний хэрээр түүхий эдийн эрэлт нэмэгдэж байсан. Гэтэл одоо энэ нь бас танагдах нь ээ гэсэн хүлээлт шинээр бий болчихлоо гэсэн үг.

-Зэсийн үнэ буурсны гол буруутан нь АНУ, еврогийн бүсийнхэн байж таарах нь?

Миний бодлоор Грекийн өр зээлийн асуудал ойрын хоёр долоо хоногт шийдэгдэх байх. АНУ-ын хувьд ч ирэх жил сонгуультай. Энэ жил эдийн засаг нь ямар байх нь нэлээд маргаан дагуулж байгаа. Харин Хятадын эдийн засаг сайн байгаа. Гэхдээ АНУ, Европын байдал урд хөршид сөргөөр нөлөөлөх эсэх нь чухал асуудал.

-Тэгэхээр айсуу хямрал манай эдийн засагт хэр хор хохирол дагуулах вэ?

-Манай эдийн засаг харьцангуй тогтвортой байх болов уу гэж найдаж байгаа. Гэхдээ түүхий эд болон гадаадын хөрөнгө оруулалтаас хэт хамааралтайгаас гадна дотоодын хөрөнгө оруулалт харьцангуй бага ийм орчинд гадаадын хөрөнгө оруулалт хумигдаад эхэлмэгц манай хөрөнгө оруулалт зогсонги байдалд орчихдог эдийн засагтай шүү дээ. Тэгэхээр хямралыг сөрөх аргын нэг нь дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэх юм. Энэ

аргыг Хятад гээд олон улсад хэрэглэж байсан. Хямрал бий болох нь гэж ойлгож байгаа тохиолдолд төр, засгийн газар, эдийн засгийн байгууллагууд нь хямралыг сөрөх бодлогоо бэлтгэсэн байх ёстой л доо. Монголбанкны зүгээс эдийн засгийн өсөлттэй байгаа хугацаанд нөөцөө нэмэх буюу ирж болзошгүй эрсдлийг давах бяр чадлаа нэмэх арга хэмжээг авсаар ирсэн. Тэгэхээр ойрын хугацаанд бид огцом цочролд орох шинж бол алга. Мэдээж, 1900 байсан алт 1600, 9000 байсан зэс 7000 болсонд бид санаа зовж байна.

-Тэгэхээр хямрал ирж байна гэсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?

-Сүүлийн 2-3 жилийн хугацаанд манай эдийн засагт бий болсон том өөрчлөлтийг харахгүй байж болохгүй. Урьд нь бидний хувь заяа зэсний үнээс л зуун хувь шалтгаалдаг байсан бол одоо нүүрсний орлого маань үүнээс давчихсан шүү дээ. Тэгэхээр манай улсын эрсдэл даах чадвар нэг биш олон зүйл дээр тогтох болсон нь сайн мэдээ. Үүнээс сургамж аваад одоо бид тогтвортой байдлаа баталгаажуулахын тулд хөрөнгө оруулалтаа бусад салбартаа оруулах нь зүйтэй болов уу гэсэн бодлогын шинж чанар бүхий бодол гарч ирж байгаа юм. Зэсээ хамгаалах нь зүйтэй л дээ. Гэхдээ энэ нь хэзээ нэгэн цагт хүчрэхгүй болдог тал 2008-2009 оны хямрал тод харуулсан шүү дээ. Тэгэхээр бизнес эрхлэгчдийн идэвхийг зогсоож болохгүй. Ер нь нийт эдийн засгийг зогсоох, ажилгүйдлийг нэмэх, хямралыг иргэдийн нуруунд шууд үүрүүлэх нь буруу. Тиймээс дэлхийн хэмжээний том хямрал айсуу гэж ярьж байгаа тохиолдолд үүнийг хэрхэн даван туулах арга замаа тов тодорхой томъёолсон байх учиртай. Энэ томъёоллын хүрээнд Төвбанкны зүгээс нөөцөө нэмэх, нийт зээлийн хэмжээ, өсөлтөд хяналт тавих, ямар зээлүүд эрсдэл рүү орох гээд байна зэрэг дээр анхаарч ажиллах ёстой юм.

-Засгийн газраас гаалийн татвар, барилгын материалын татвар нэмэгдсэн шүү дээ. Энэ нь хямрал үүсэх айдаст хэрхэн нөлөөлөх бол?

-Татвар нэмнэ гэдэг шууд үнэ нэмэгдэхтэй адил. Харамсалтай нь Засгийн газар энэ тал руугаа оролцоод байх юм бол бидэнд санаа зовох зүйл бий болж эхэлнэ. Дэлхийн зах зээлд үүсч буй асуудлын эсрэг бид сулруулах ёстой атал улам чангалаад эхлэх юм бол үржүүлгийн хурдаар асуудал бий болох болов уу.

-Эдийн засагч хүний тань хувьд 1997, 2008 оны гээд хэд хэдэн хямралаас харахад юу ажиглагдаж байх юм?

-Хямралын эхэн үед хямралаа сайн олж хардаггүй юм байна. Харин дунд үед нь эхлэлийг нь дүгнэдэг. Эцсийн шатандаа хямралын ид буюу дунд үеийнхээ гашууныг л яриад байдаг юм байна. Харин хямрал дууссан хойно маргааш, ирээдүйгээ яриад явчихдаг. Тэгэхээр бидний зүгээс зах зээлийг маш хянамгай ажиглах ёстой цаг үе юм. Гэхдээ дэлхийн эдийн засаг тэр дундаа түүхий эдийн зах зээл ийм л хэлбэлзэлтэй явсаар ирсэн. Харин энэ хэлбэлзэл нь сүүлийн жилүүдэд эерэг талдаа удсан учраас дэлхийн зах зээлийн шинжээчдийн хэлдгээр коррекц буюу засвар хийгдэж байгаа гэж ойлгож болно. Түүхий эд үнэхээр үнэтэй болчихсон байсан шүү дээ. Оны эхээр 1350 байсан алтны ханш 1900 хүрээд эргээд 1600 боллоо, нүүрсний үнэ 80 хувиар өссөн

байсан шүү дээ. Тэгэхээр энэ бүхэн буцаад засагдаж байна гэж ойлгож болох нь. Түүнээс том хэмжээний хямрал гээд байх зүйл одоохондоо ажиглагдаагүй л болов уу.

-Ийм хямрал айсуу байгааг ОУВС-гаас сануулахын зэрэгцээ төсөвт тодотгол хийхийг буруу гэж үзсэн. Төсвийн тодотгол муу үр дагавар дагуулах болов уу?

-Угаасаа төсөв Төсвийн тодотгол нэг их том дүнгээр биш байх шиг байсан. Иргэдэд тарааж буй 21 мянган төгрөг чинь жилийн 700-800 тэрбум төгрөг шүү дээ. Тэгэхээр ийм том хэмжээний засвар биш байх гэж бодож байна. Зүгээр урсгал зардлаа зохицуулж байгаа байх.

А.АРИУНБОЛД